



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Их-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/134/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2024 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улаангай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.22 № 67

танай _____ -ны № _____ -т

ИХ-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Э.УДВАЛ-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Их-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Их-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Их-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь тайланд онд сумын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд орон нутгийн хөрөнгө оруулалт болон аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 245,000.0 мянган төгрөгийн, сумын орон нутгийн хөгжлийн сангаас баяр наадмын талбай, Баян-Ухаа цогцолбор, үндэсний сурын талбай зэрэг 498,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Мөн үер усны байгалийн гамшиг болж аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 20,000.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Их-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар төсвийн хөрөнгөөс 3,175.8 мянган төгрөгийн шатахууныг үрэлгэн зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөнийг илрүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Их-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь зочид буудал, халуун ус, давхар контор, 4 машины граж, зоорь, баяр наадмын талбай, сүүний үйлдвэрийн барилгын газрыг үнэлж, данс бүртгэлд тусгаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Audit(D)A4Албан бичиг/2024

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>173,068,440.2</u>	<u>375,282,190.3</u>
33	АВЛАГА	8,594,001.0	83,370,741.1
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	370,741.1
335	Бусад авлага	8,594,001.0	83,000,000.0
3351	Байгууллагаас авах авлага	291,401.0	80,000,000.0
3352	Хувь хүмүүсээс авах авлага	8,302,600.0	3,000,000.0
35	БАРАА МАТЕРИАЛ	164,474,439.2	291,911,449.2
351	Түүхий эд материал	52,952,809.2	148,999,759.2
35110	Тусгай зориулалттай материал	52,952,809.2	148,999,759.2
354	Хангамжийн материал	104,683,630.0	136,073,690.0
35410	Бичиг хэргийн материал	2,682,800.0	2,187,400.0
35420	Аж ахуйн материал	102,000,830.0	133,886,290.0
35600	Мал амьтад	6,838,000.0	6,838,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,017,732,345.0</u>	<u>1,521,389,359.7</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,017,732,345.0	1,521,389,359.7
392	Биет хөрөнгө	983,864,345.0	1,488,001,359.7
39201	Барилга, байгууламж, орон сууц	759,130,585.3	1,045,386,561.3
39202	Хуримтлагдсан элэгдэл	(169,448,567.7)	(204,296,679.3)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	303,738,800.0	429,738,800.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(188,664,095.2)	(210,675,257.1)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	268,909,595.0	317,309,595.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(190,167,331.2)	(211,414,759.1)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,008,183.0	61,621,513.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,249,118.2)	(26,181,736.5)
39214	Бусад үндсэн хөрөнгө	289,184,344.0	423,577,944.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	(107,842,049.9)	(137,328,621.7)
39217	Ном	264,000.0	264,000.0
393	Биет бус хөрөнгө	33,868,000.0	33,388,000.0
39301	Програм хангамж	2,600,000.0	2,600,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,400,000.0)	(1,880,000.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	32,668,000.0	32,668,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,190,800,785.3</u>	<u>1,896,671,550.0</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,190,800,785.3</u>	<u>1,896,671,550.0</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,190,800,785.3	1,896,671,550.0
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	391,748,377.0	391,748,377.0
51101	Өмч: - төрийн	391,748,377.0	391,748,377.0
512	Хуримтлагдсан үр дүн	609,386,507.0	1,315,257,271.7
51210	Өмнөх үеийн үр дүн	191,224,458.2	609,386,507.0
51220	Тайлант үеийн үр дүн	418,162,048.8	705,870,764.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	189,665,901.3	189,665,901.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,190,800,785.3</u>	<u>1,896,671,550.0</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,187,610,800.9	1,782,578,907.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	440,692,550.9	673,711,510.0
120	Нийтлэг татварын бус орлого	440,692,550.9	673,711,510.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	440,692,550.9	673,711,510.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	440,692,550.9	673,711,510.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	746,918,250.0	1,108,867,397.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	233,593,850.0	345,028,232.1
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	222,878,800.0	326,130,232.1
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,715,050.0	18,898,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	513,324,400.0	763,839,165.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	513,324,400.0	763,839,165.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	769,443,668.0	1,076,708,141.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	769,443,668.0	1,076,708,141.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	724,158,617.0	1,010,705,008.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	286,035,582.0	418,226,227.4
210101	Үндсэн цалин	209,279,733.0	268,767,603.3
210102	Нэмэгдэл	65,247,652.0	106,233,415.0
210104	Урамшуулал	11,508,197.0	43,225,209.1
2102	Ажил олгогчоос НД-Д төлөх шимтгэл	35,820,559.0	52,872,176.6
210201	Тэтгэврийн даатгал	25,215,421.0	36,377,243.6
210202	Тэтгэмжийн даатгал	2,897,420.0	4,241,488.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,314,576.0	3,393,190.0
210204	Ажилгүйдлийн даатгал	484,177.0	805,478.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,908,965.0	8,054,777.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,540,241.0	70,718,723.0
210301	Гэрэл, цахилгаан	7,090,001.0	7,029,923.0
210302	Түлш, халаалт	24,450,240.0	63,688,800.0
2104	Хангамж, бараа материалын зардал	63,343,036.0	80,033,207.0
210401	Бичиг хэрэг	5,208,180.0	6,052,300.0
210402	Тээвэр, шатахуун	51,270,806.0	61,988,037.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,605,000.0	2,978,700.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,259,050.0	9,014,170.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,081,000.0	19,725,100.0
210604	Урсгал засвар	18,081,000.0	19,725,100.0
2107	Томилолт, зочны зардал	6,768,000.0	10,043,800.0
210702	Дотоод албан томилолт	6,768,000.0	10,043,800.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,790,472.0	94,047,425.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,879,179.0	93,102,611.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	456,819.0	169,500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.0	182,800.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73,550.0	-
210807	Газрын төлбөр	638,300.0	592,514.0

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний	14,924.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	271,779,727.0	265,038,349.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	192,994,034.0	119,633,730.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	125,000.0	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,660,693.0	145,404,619.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,285,051.0	66,003,132.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,835,800.0	60,246,700.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	25,835,800.0	60,246,700.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,449,251.0	5,756,432.9
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,449,251.0	5,756,432.9
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>418,167,132.8</u>	<u>705,870,765.8</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>418,167,132.8</u>	<u>705,870,765.8</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<u>746,918,250.0</u>	<u>1,108,867,397.1</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>746,918,250.0</u>	<u>1,108,867,397.1</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	233,593,850.0	345,028,232.1
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	222,878,800.0	326,130,232.1
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,715,050.0	18,898,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	513,324,400.0	763,839,165.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	513,324,400.0	763,839,165.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>609,943,166.0</u>	<u>989,476,992.0</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>609,943,166.0</u>	<u>989,476,992.0</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>564,658,115.0</u>	<u>923,473,859.1</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	285,250,399.0	419,244,866.1
210101	Үндсэн цалин	220,273,718.0	265,108,257.4
210102	Нэмэгдэл	50,885,420.0	115,430,657.0
210104	Урамшуулал	13,736,731.0	38,705,951.7
210105	Гэрээт ажлын хөлс	354,530.0	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,131,200.0	52,224,279.0
210201	Тэтгэврийн даатгал	25,906,700.0	35,642,879.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,558,300.0	4,194,100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,068,600.0	3,355,200.0
210204	Ажилгүйдлийн даатгал	517,100.0	819,400.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,080,500.0	8,212,700.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,817,741.0	70,718,723.0
210301	Гэрэл, цахилгаан	7,090,001.0	7,029,923.0
210302	Түлш, халаалт	22,727,740.0	63,688,800.0
2104	Хангамж, бараа материалын зардал	32,549,100.0	49,967,147.0
210401	Бичиг хэрэг	6,409,300.0	5,291,900.0
210402	Тээвэр, шатахуун	23,384,800.0	41,271,547.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,755,000.0	3,403,700.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,339,400.0	4,086,700.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,200,000.0	-

210604	Урсгал засвар	4,139,400.0	4,086,700.0
2107	Томилолт, зочны зардал	6,618,000.0	9,335,800.0
210702	Дотоод албан томилолт	6,618,000.0	9,335,800.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,016,993.0	183,989,224.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,105,700.0	183,044,410.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	456,819.0	169,500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.0	182,800.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73,550.0	-
210807	Газрын төлбөр	638,300.0	592,514.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	14,924.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	146,935,282.0	133,907,120.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	146,634,602.0	133,907,120.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,680.0	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,285,051.0	66,003,132.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,835,800.0	60,246,700.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,835,800.0	60,246,700.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,449,251.0	5,756,432.9
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,449,251.0	5,756,432.9
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	136,975,084.0	119,390,405.1
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	136,970,000.0	119,390,404.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	136,970,000.0	119,390,404.0
2200	Дотоод эх үүсвэрээр	136,970,000.0	119,390,404.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	136,970,000.0	119,390,404.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(136,970,000.0)	(119,390,404.0)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,084.0	1.1

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	388,066,377.0	189,665,901.3	191,224,458.2	768,956,736.4
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	388,066,377.0	189,665,901.3	191,224,458.2	768,956,736.4
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	3,682,000.0	-	-	3,682,000.0
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	418,162,048.8	418,162,048.8
C08	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	391,748,377.0	189,665,901.3	609,386,507.0	1,190,800,785.3
D01	2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	391,748,377.0	189,665,901.3	609,386,507.0	1,190,800,785.3
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	391,748,377.0	189,665,901.3	609,386,507.0	1,190,800,785.3
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	705,870,764.7	705,870,764.7
D09	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	391,748,377.0	189,665,901.3	1,315,257,271.7	1,896,671,550.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ЗЗА	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	800,613,100.0	758,082,732.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	800,613,100.0	758,082,732.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	740,366,400.0	697,836,032.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	419,406,300.0	419,244,866.1
210101	Үндсэн цалин	304,968,000.0	265,108,257.4
210102	Нэмэгдэл	114,438,300.0	115,430,657.0
210104	Урамшуулал	-	38,705,951.7
2102	Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	52,426,400.0	52,224,279.0
210201	Тэтгэврийн даатгал	35,649,500.0	35,642,879.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,194,100.0	4,194,100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,355,800.0	3,355,200.0
210204	Ажилгүйдлийн даатгал	838,800.0	819,400.0
210205	Эрүүл мэндийн даатгал	8,388,200.0	8,212,700.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,533,800.0	70,718,723.0
210301	Гэрэл, цахилгаан	7,944,800.0	7,029,923.0
210302	Түлш, халаалт	63,589,000.0	63,688,800.0
2104	Хангамж, бараа материалын зардал	33,997,500.0	33,776,100.0
210401	Бичиг хэрэг	5,357,200.0	5,291,900.0
210402	Тээвэр, шатахуун	25,100,500.0	25,100,500.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,539,800.0	3,383,700.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,773,500.0	2,771,700.0
210604	Урсгал засвар	2,773,500.0	2,771,700.0
2107	Томилолт, зочны зардал	8,414,500.0	8,395,800.0
210702	Дотоод албан томилолт	8,414,500.0	8,395,800.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,284,600.0	944,814.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.0	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	560,000.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.0	169,500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.0	182,800.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73,800.0	-
210807	Газрын төлбөр	638,300.0	592,514.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15,700.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	149,529,800.0	109,759,750.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	149,376,400.0	109,759,750.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	153,400.0	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,246,700.0	60,246,700.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,246,700.0	60,246,700.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	60,246,700.0	60,246,700.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	800,713,100.0	758,082,732.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	800,413,100.0	758,082,732.1
122005	Орон нутгийн төсвөөс	800,413,100.0	758,082,732.1

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	345,028,231.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	345,028,231.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	345,028,231.0
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	16,191,047.0
210402	Тээвэр, шатахуун	-	16,171,047.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	20,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	2,338,600.0
210604	Урсгал засвар	-	2,338,600.0
2107	Томилолт, зочны зардал	0.00	940,000.0
210702	Дотоод албан томилолт	-	940,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	283,041,214.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	283,041,214.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	42,517,370.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	42,517,370.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	345,028,231.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	345,028,231.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	326,130,231.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	18,898,000.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Их-Уул сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэл:

- Иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх

Их-Уул сумын Засаг даргын Тамгын газрын зорилго: Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж мэргэшсэн төрийн албан хаагчаар төрийн албыг бүрдүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг ил тод шуурхай тэгш хүртээмжтэй хүргэх, сум орон нутгаа хөгжүүлэх гэсэн зорилго зорилт чиг үүргийн хүрээнд ажилладаг байна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 92 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 87 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Их-Уул сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд Тамгын газрын дарга, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Их-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Их-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 705,870.7 мянган төгрөгөөр буюу 59.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	8,594.0	83,370.7	74,776.7
Бараа материал	164,474.4	291,911.4	127,437.0
Үндсэн хөрөнгө	1,017,732.3	1,521,389.3	503,657.0
Нийт хөрөнгө	1,190,800.8	1,896,671.5	705,870.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,190,800.8	1,896,671.5	705,870.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,190,800.8	1,896,671.5	705,870.7

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Авлагын эхний үлдэгдэл 8,594.0 мянган төгрөг, тайлант онд 5,396.3 мянган төгрөгийн авлага барагдаж, 80,173.6 мянган төгрөгийн авлага нэмэгдэж, эцсийн үлдэгдэл 83,370.7 мянган төгрөг болсон байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 164,474.4 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 147,968.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 144,040.3 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 164,571.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 291,911.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 127,437.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 119,390.4 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 529671.2 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 33,398.7 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрийн дагуу акталж, жилийн эцэст 1,521,389.3 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 145,404.6 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 705,870.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 622,279.6 мянган төгрөг, нийт зарлагыг 622,279.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, Засаг даргын нөөц хөрөнгийг тодотголоор нэмж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 800,413.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 758,082.7 мянган төгрөг буюу 94.7 хувьтай байна. Энэ нь гэрэл цахилгаан, шуудан холбоо, хичээл үйлдвэрлэлийн дадлага, мэдээлэл сурталчилгаа зэрэг зардлыг 2,391.6 мянган төгрөгөөр, Засаг даргын нөөц хөрөнгөөс 21,112.2 мянган төгрөг, байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас 18,504.5 мянган төгрөгийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага				
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	483,879.5	481,787.9	2,091.6	99.6%
80106	Баг, хорооны үйл ажиллагааны зарлал	106,610.5	106,288.4	322.1	99.7%
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	300.0	-	300.0	0%

80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	60,246.7	60,246.7	-	100%
81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	73,000.0	51,887.8	21,112.2	71.1%
81701	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	76,376.4	57,871.9	18,504.5	75.8%
НИЙТ		800,413.1	758,082.7	42,330.4	94.7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 345,028.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлснээс 275,000.0 мянган төгрөгийн орлого нь аймгийн орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн хөрөнгө оруулалтаас эрх шилжсэн 6 ажлын санхүүжилт байна. Гүйцэтгэлээр 345,028.2 мянган төгрөгийг тээвэр шатахуун, шуудан холбоо, урсгал засвар, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Нээлттэй тендер шалгаруулалт	Хүүхдийн 2-р цэцэрлэгийн барилгын засвар	40,000.0	40,000.0
2	Нээлттэй тендер шалгаруулалт	"Тэр бум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд элсний нүүдлийг сааруулах хаалт хийх, цэцэрлэгжүүлэх	100,000.0	80,000.0
3	Нээлттэй тендер шалгаруулалт	Иргэний хөгжлийн төвийн их засвар	100,000.0	100,000.0
4	Шууд гэрээ байгуулах	Хуягт багийн Тосонгийн даваа, өндөр гүвээний зам засварын ажил	20,000.0	20,000.0
5	Шууд гэрээ байгуулах	Солонготын давааны тохижилт засвар	20,000.0	20,000.0
6	Шууд гэрээ байгуулах	Сумын ЗДТГ-ын барилгын засвар	15,000.0	15,000.0
ДҮН			295,000.0	275,000.0

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Их-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Их-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 03/11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 1,165,445.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 17,481.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13.111.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, санхүүгийн үр дүнгийн тайлан өөрчлөгдсөн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн, үр дүнгийн тайлангийн 1,076,708.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 16,150.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 12.113.0 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 37 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Их-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 449,682.0 мянган төгрөгийн зөрчилд 5 заалт зөвлөмж, 15,852.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	15,852.2	1	15,852.2	100%
Зөвлөмж	5	449,682.0	5	449,682.0	100%
Нийт дүн	6	465,534.2	6	465,534.2	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 214,294.0 мянган төгрөгийн алдаа илэрч, аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

Тайлант онд худалдаж авсан 113,390.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжиж ирснээр, 3,900.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тавилга эд хогшил дансанд бүртгэж тайлагнасан, тайлант оны элэгдлийн зардлыг 10,829.9 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон, тайлант онд үүссэн 80,000.0 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, 173.6 мянган төгрөгийн НДШ-ийн авлагыг санхүүгийн тайланд дутуу тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасан, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-тай нийцэхгүй, толилуулга, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 3,175.8 мянган төгрөгийн зөрчил илэрч, шатахуун үрэлгэн зарцуулсан болон газрын нэгдсэн санд бүртгэлтэй газрыг үнэлж, данс бүртгэлд тусгаагүй зөрчилд 2 заалт зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн 3,175.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 12,979.4 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

5.2 Албан шаардлага өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зориулалт бус зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шатахууны зардлаас 3,175.8 мянган төгрөгийн шатахууныг албан бус хэрэгцээнд үрэлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахууны зардлыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, албан бус хэрэгцээнд шатахуун зарцуулахгүй байх,

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Барилга байгууламж болон бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй Зочид буудал, халуун ус, давхар контор, 4 машины гараж, зоорь, баяр наадмын талбай, сүүний үйлдвэрийн барилгын газрыг үнэлж, данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.8-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй Зочид буудал, халуун ус, давхар контор, 4 машины гараж, зоорь, баяр наадмын талбай, сүүний үйлдвэрийн барилгын газрыг үнэлж, данс бүртгэлд тусгах;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруу-лаагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд худалдаж авсан 113,390.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжиж ирснээр, 3,900.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тавилга эд хогшил дансанд бүртгэж тайлагнасан.	1	123,290.4			1	123,290.4	1	123,290.4				
Тайлант онд үүссэн 80,000.0 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, 173.6 мянган төгрөгийн НДШ-ийн авлагыг дутуу тусгасан байна.	1	80,173.6	1	80,173.6			1	80,173.6				
Тайлант оны элэгдлийн зардлыг 10,830.0 мянган төгрөгөөр дутуу тооцолсон байна.	1	10,830.0			1	10,830.0	1	10,830.0				
Дүн	3	214,294.0	1	80,173.6	2	134,120.4	3	214,294.0				

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шатахууны зардлаас 3,175.8 мянган төгрөгийн шатахууныг албан бус хэрэгцээнд үрэлгэн зарцуулсан	1	3,175.8					1	3,175.8				

/мянган төгрөгөөр/

Барилга байгууламж болон бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй Зочид буудал, халуун ус, давхар контор, 4 машины гараж, зоорь, баяр наадмын талбай, сүүний үйлдвэрийн барилгын газрыг үнэлж, данс бүртгэлд тусгаагүй	1			1		
Дүн	2	3,175.8		2	3,175.8	

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

Д.БАТ-УНДРАА



Огноо: 2024-02-23

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

Ц.ОЮУНСУВД

Огноо: 2024-02-23